



COVID-19 БА ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ

Монгол Улсын Үндэсний Статистикийн сүүлийн үеийн мэдээллээр Монгол Улсын эдийн засаг COVID-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор 2020 оны эхний улирлын байдлаар 10,7 хувь агшаад байна. БНХАУ-ын эдийн засгийн удаашралын улмаас ашигт малтмалын түүхий эдийн эрэлт багассан нь Монгол Улсын нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, газрын тосны экспорт буурч, эдийн засаг агшихад хүргэсэн байна. Үүний нөлөөгөөр төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 767.0 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 368.9 сая ам.доллараар өссөн байна. Мөн манай улсын үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж эхэлж байгаа ажээ. Тухайлбал, түүхий эд, материал болон сэлбэг, эд ангиа гаднаас импортолдог цаас, цаасан бүтээгдэхүүн, мод, модон эдлэл, резин болон хуванцар бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн, тамхи, тавилга, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын борлуулалт 2020 оны эхний 4 сард 2.5-58.9 хувиар буурсан байна. Түүнчлэн, 2020 оны эхний 5 сарын байдлаар улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс:

- Инфляци 3.3%
- Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 19.0%
- Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 34.6%
- Боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл 16.1%
- Экспорт 38.5%
- Импорт 13.9%-иар тус тус буурсан бол улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээлийн хэмжээ 29.3%, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 39.5%, ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн хэмжээ 39.0%-иар тус тус өсчээ.

Цаашилбал, цар тахал болон түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотойгоор, бүх төрлийн үйлчилгээний газрын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, ресторан болон бусад нийтийн хоолны газруудын ажиллах цагийн хуваарийг багасгаснаар¹ дотоодын аж ахуйн нэгжүүд хүндрэлтэй нөхцөлтэй тулгарч байна. Тухайлбал, зочид буудлын салбарын нийт орлого 2020 оны эхний улиралд өмнөх улирлаас 56%, нийтийн хоолны салбарын орлого 20.1% буурсан байна.

Нөгөө талаар, бүх шатны боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосны нөлөөгөөр ханиад, томуугийн дэгдэлт, амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин

¹ Нийслэлийн засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/223 тоот захирамж

мэдэгдэхүйц буурахад нөлөөлжээ. Үйлчилгээний газар, баар, цэнгээний газруудыг хэсэгчлэн хааж, цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, иргэдийг аль болох гэртээ байхыг уриалж байгаа нь гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлж байгаа боловч, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нэмэгдэх шалтгаан болж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 61.6 хувиар өссөн байна.

Өмнө нь мэдээлж байсанчлан, Монгол Улс нь COVID-19 цар тахлын эсрэг “Өндөржүүлсэн бэлэн байдал”-ын зэрэгт шилжиж, 2 сараас хойш бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаа, жагсаал цуглаан, нийтийг хамарсан арга хэмжээ болон үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагааг зогсоож, өнөөдрийг хүртэл хугацааг нь сунгасаар ирсэн. Гэвч энэ хугацаанд зарим нэг сургалтын үйл ажиллагаа, фитнес клуб болон усан бассейн зэргийг тодорхой дэглэмийн дор үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн. 2020 оны 7-р сарын 1-ны өдрийн Улсын Онцгой Комиссын хуралдаанаар Өндөржүүлсэн Бэлэн Байдлын хугацааг тус сарын 15-ны өдрийг хүртэл сунгахаар шийдвэрлэсэн байна. Энэ удаад жагсаал цуглаан, нийтийг хамарсан үйл ажиллагаа, РС тоглоомын газар, диско болон шөнийн клубээс бусад бүх төрлийн хүүхдийн тоглоомын газар, баар, биллиард, шашин, соёл урлаг, үзвэр, үйлчилгээний газрын үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн үе шаттайгаар нээхийг зөвшөөрөхөөр шийдвэрлэжээ. Хил нээхгүй байхаар шийдвэрлэсэн хэдий ч Засгийн газраас иргэдээ бусад орнуудаас тусгай нислэгээр авчирсаар байна. Тухайлбал, 6 сард 2000 орчим иргэдээ авчирсан бол, энэ 7 сард 3000 орчим иргэдээ авчрахаар төлөвлөөд байна.

Эх сурвалж:

1. Монгол Улсын Онцгой Комиссын 2020 оны 7 дугаар сарын 1 өдрийн хуралдааны тэмдэглэл <https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/07/%D0%A3%D0%9E%D0%9A-%D1%8B%D0%BD-2020-%D0%BE%D0%BD%D1%8B-25-%D1%80-%D1%85%D1%83%D1%80%D0%BB%D1%8B%D0%BD-%D1%82%D1%8D%D0%BC%D0%B4%D1%8D%D0%B3%D0%BB%D1%8D%D0%BB.pdf>
2. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вирус-ээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний нөлөөлөл – Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, 2020 https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=covid_aanb_2020.pdf&ln=Mn
3. Коронавирус ба эдийн засаг 5 сар – Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, 2020.06.16 https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=COVID-19_2020.05.pdf&ln=Mn

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, GRATA International Хуулийн Фирмийн партнер В.Болормаа болон хуульч Т.Буянжаргалтай bvolodya@gratanet.com, btungalag@gratanet.com эсхүл +976 70155031 утсаар холбогдоорой.